



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛ**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн  
чөлөө-3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас:(976)70444414  
Цахим шуудан:bhr-salbarzuvlul@csc.gov.mn  
Цахим хаяг:csc.gov.mn

2022.06.27 № 127

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛД Г

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 6.1 дэх хэсэгт заасны дагуу тус Салбар зөвлөлийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, холбогдох материалыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт .. хуудастай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

642226107

Боловсруулсан  
Хянасан  
2 хувь бичсэн Г.Уранцэдэг  
2022.06.27



Б.Нямдулам  
Д.Энхжаргал



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

### МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 01 дүгээр сарын 10

Номгон

#### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл нь 2021 онд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 94, 2021 оны 16 дугаар тогтоолоор 8 хүний бүрэлдэхүүнтэй томилогдож, 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 138 дугаар тогтоолоор 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилогдон ажиллаж байна.

Тус салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэр, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### **1.1 Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, энэ талаар харьяалах байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байдал:**

Аймгийн хэмжээнд төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор тус салбар зөвлөлөөс 2022 оныг “**ТӨРИЙН АЛБАНЫ МАНЛАЙЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭН, ЁС ЗҮЙ, ЧАДАВХУЙН ЗАРЧМЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАР ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ**” жил болгон зарлаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгдүгээр хуралдаанаараа хэлэлцэн 4 зорилт 18 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, эхний хагас жилийн байдлаар 86.6 хувийн биелэлтэйгээр хэрэгжилтийг зохион байгуулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.2, 5 дугаар зүйлийн 5.7-т заасан чиг үүргийн хүрээнд Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хууль, тогтоомжийг сурталчлан



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

таниулах зорилгоор аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны болон үйлчилгээний 181 байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах ажлыг 2022 оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.

Төрийн албаны тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилт, Төрийн албаны Зөвлөлөөс гаргасан 18 удаагийн үүрэг чиглэл өгөх, судалгаа, мэдээлэл авах тухай албан бичиг ирүүлснийг тухай бүрд шийдвэрлэн ажиллалаа.

Эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийн хүрээн дэх төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн баталгаа, сургалт хөгжил, ёс зүйн зөрчил, сахилга хариуцлага, хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системийн бүртгэл, хөтлөлт, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зэрэг асуудлаар давхардсан тоогоор нийтдээ 5.000 гаруй төрийн албан хаагч, иргэдэд биечлэн, утсаар, албан бичгээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

### **1.2 Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах, энэ талаар үүрэг даалгавар, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал:**

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, дүрэмд заасны дагуу 25-аас дээш албан хаагчтай байгууллагуудад “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах талаар салбар зөвлөлийн 3 удаагийн албан бичгийг хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Аймгийн 181 төрийн байгууллагын **97** нь ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллаж, байгууллагын дэргэдэх **Ёс зүйн зөвлөлүүд** нийт **123 удаагийн** сургалт, зөвлөгөө, мэдээллийг **1387** төрийн албан хаагчдад өгч ажиллажээ.

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар байгууллагуудын Дотоод журам, Хамтын гэрээ, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн гэрээнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн 3 зөрчлийг тэмдэглэснээс уучлал гуйлгуулах шийтгэлийг 1, сануулах шийтгэлийг 2 тус тус ногдуулжээ.



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэлгүй, ажлын сахилга, хариуцлага алдсан зэрэг шалтгаанаар 27 төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Салбар зөвлөл, Хууль эрх зүйн хэлтэс хамтран Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар 5 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, 216 төрийн албан хаагчийг хамруулан сургалт, мэдээлэл хийсэн.

Төрийн албан хаагчид ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар давхардсан тоогоор 300 гаруй төрийн албан хаагч, иргэдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

### **"ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА ЗӨВТЭЙ ТӨРИЙН АЛБА" АЯНЫГ 2 ДАХЬ ЖИЛДЭЭ 3 САРЫН ХУГАЦААНД ӨРНҮҮЛЖ, ҮР ДҮНГ ДҮГНЭВ.**

Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор **"Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба"** аяныг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний хооронд зохион байгууллаа.

#### **Аяны хүрээнд:**

1.Төрийн байгууллагууд иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаагаа хялбаршуулж давхардсан тоогоор 12 төрийн үйлчилгээгээ QR кодлуулжээ.





## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ



2. “ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЭЛЬЕ-ШИНЭЧЛЭЛИЙГ ШИЛДГЭЭСЭЭ СУРАЛЦЪЯ” уриан доор нийт 28 төрийн байгууллага шилдэг ажилчдынхаа туршлагыг түгээх сургалт, уулзалтуудыг зохион байгуулж, төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн байна.



3. Аймгийн төвийн 24 байгууллага, 4 сум “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгууллаа.



Нээлттэй хаалганы өдөрлөгөөр байгууллагууд 50 гаруй төрлийн үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилж, иргэдийн гомдол, санал, хүсэлтийг сонсох, хүлээн авах, газар дээр нь үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэж



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

болохуйц санал хүсэлтийг тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан байна.

Өдөрлөгийн үеэр нийтдээ 5000 гаруй төрийн албан хаагчдад шуурхай үйлчилгээ, мэдээллийг өгч ажиллав.



4. Төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагын өнөөгийн байдлыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх бодлого чиглэл, ажил, арга хэмжээнд ашиглах зорилгоор **Ёс зүй, харилцаа, хандлагын талаарх судалгааг аймгийн 85 байгууллагын 455 албан албан хаагчдаас авлаа.**

Судалгаагаар тус аймгийн нийт төрийн байгууллагын 90 хувь нь байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөлөө байгуулан ажилладаг ч үйл ажиллагаа нь хангалттай сайн биш, жилд 1-2 удаа сургалт зохион байгуулдаг гэжээ.

Төрийн байгууллагууд удирдлага, албан хаагчид, ажилхдаас гарсан санал хүсэлтүүдийг дурьвал:

- Ёс зүйн зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх;
- Ёс зүйн зөвлөлийг нээлттэй сонгодог болох;
- Боловсролын байгууллагууд сэтгэл зүйчтэй болох;
- Хагас бүтэн жилээр хийсэн ажлыг тайлагнадаг болох;
- Зөвлөлийн гишүүд урамшуулал авдаг байх.



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

5. “Зөв харилцаа-ээрэг хандлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албаны үнэт зүйлс зэрэг сэдвээр нийтдээ **23** байгууллага, 1200 гаруй төрийн албан хаагчдад сургалт мэдээлэл өгч ажиллажээ.

Энэ сарын 21-ний өдөр зохион байгуулсан Канадын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Салбар зөвлөл хамтран “Төрийн албан хаагчийн шударга, зарчимч байдал ба стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага” сэдэвт сургалтын үеэр “Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба” аяны тайлан, үр дүнг салбар зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, аяны хүрээнд тавьсан зорилтуудыг үр дүнтэйгээр хэрэгжүүлж ажилласан учир урамшуулах шийдвэр гарган, 9 байгууллагад талархал гардуулсан.

### Аяныг зохион байгуулснаар дараах үр дүнд хүрсэн.

- ✓ Аймгийн хэмжээнд төрийн албаны нэр хүнд дээшилж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдсэн.
- ✓ Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг сурталчлан, таниулах зэрэг ажлыг эрчимжүүлсэн нь **Төрийн албаны шинэтгэлийн** бодлогыг хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болж байна.
- ✓ Салбар зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбох өргөдөл, гомдлын тоо 33 хувиар буурав.

### **1.3 Салбар зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэрлэлт:**

Тус Салбар зөвлөл нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 8 удаагийн хуралдааныг хийж, эрх хэмжээний хүрээнд 14 асуудлыг хэлэлцэн 19 тогтоол шийдвэр гаргаж, хэрэгжилтийг 100 хувь зохион байгуулав.








## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ



Салбар зөвлөлийн 2022 оны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын агуулга:



Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 126 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, үүнээс орон нутгийн хэмжээнд Төрийн албаны тухай хууль, тогтоомж, төрийн албаны стандарт, Төрийн албаны зөвлөлөөс гаргаж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн хариуг хүргүүлэх чиглэлээр 64, аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудад чиглэл хүргүүлсэн 47, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариуг хүргүүлсэн 15 албан бичгийг тус тус гаргалаа.




## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Тайлант хугацаанд **353** албан бичиг ирснээс хариутай 102 албан бичгийг 90 хувьтай шийдвэрлэж ажиллалаа.


Салбар зөвлөлд иргэдээс нийт 12 өргөдөл, гомдол ирүүлснийг хуралдаанаар хэлэлцэн 12 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, хариуг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувь байна.

### Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо:



### Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлыг:

#### Агуулгаар нь ангилвал:



#### Шийдвэрлэлт





## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

**Хоёр. Төрийн албаны нөөц бүрдүүлэх талаар:**

**2.1 Харьяалах байгууллагын “Хүний нөөцийн удирдлагын систем”-д мэдээлэл оруулж, төрийн байгууллагыг төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөхөд мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан байдал:**

Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх журам”-ын дагуу тус салбар зөвлөлд харьяалагдах 181 төрийн байгууллага дээрх системийг хөтлөн явуулдаг.

Салбар зөвлөлөөс “Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба” аяныг зарлаж, аяны хүрээнд төрийн байгууллагууд улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөлтийн үйл ажиллагааг эрчимжүүлж, 20 байгууллага бүрэлдэхүүн хөдөлгөөний программд дахь төрийн албан хаагчдын мэдээлэлд шинэчлэлт хийж ажилласан байна.




“Хүний нөөцийн удирдлагын систем”-д мэдээлэл оруулж, төрийн байгууллагыг төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөх талаар Салбар зөвлөлийн 1 удаагийн албан бичгээр хугацаатай үүрэг чиглэлийг 181 төрийн байгууллагад хүргүүлж, биелэлтэд хяналт тавив.





## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Төрийн албаны улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх, хүний нөөцийн цахим системд мэдээлэл оруулах талаар 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 179 төрийн байгууллагын давхардсан тоогоор 200 гаруй удирдах болон гүйцэтгэх албан хаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн, [www.facebook.com](http://www.facebook.com) /Баянхонгор Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтны групп чат, ТАЗ-ийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл гэсэн удирдах ажилтнуудын групп чат/-аар тус тус мэдээллийг түгээн холбогдох асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.



### Гурав. Төрийн албаны шалгалт зохион байгуулсан талаар:

#### 3.1 Төрийн албаны Ерөнхий шалгалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байдал:

Төрийн албаны ерөнхий нөөц бүрдүүлэх шалгалтыг 2022 оны 04 дүгээр сард Төрийн албаны ерөнхий шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тов, чиглэлийн дагуу 4 дүгээр сард шалгалтыг зохион байгуулж, 62 иргэний ерөнхий нөөцийг бүрдүүллээ.

#### 2022 оны байдлаар төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг зохион байгуулсан тухай





## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Тус аймагт төрийн албаны ерөнхий шалгалтад орж, нөөцөд бүртгэгдэж буй иргэдийн шалгалтын онооны үзүүлэлт өмнөх оны дүнтэй харьцуулахад өссөн нь аймгийн хэмжээнд төрийн албаны ерөнхий шалгалтын мэдээллийн хүртээмж сайжирч, иргэдийн мэдлэг, мэдээлэл болон шалгалтад бэлдэж оролцох хандлага өөрчлөгдсөнийг доорх чанарын үзүүлэлт харуулж байна.

### 3.2 Төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийн байдал:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, Төрийн албаны зөвлөлийн 25 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу 2022 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 1 удаагийн 11 сул орон тоог нөхөх шалгалтыг нийтэд зарлан, зохион байгуулж, 8 сул орон тоог нөхсөн. *2022 оны эхний хагас жилийн байдлаар ТҮБТШЗ-ийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан талаар:*



Эхний хагас жилийн байдлаар Төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх албан тушаалын 4 удаагийн давхардсан тоогоор 326 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг нийтэд зарлаж, 3 удаагийн шалгалтыг зохион байгуулж, 77 сул орон тоог нөхсөн. Сүүлийн зарласан шалгалтыг 2022 оны 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулна.



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Мөн төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалын 4 удаагийн давхардсан тоогоор 38 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг нийтэд зарлаж, 3 удаагийн шалгалтыг зохион байгуулж, 14 сул орон тоог нөхсөн. Сүүлийн нийтэд зарласан шалгалтыг 2022 оны 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулна.

*2022 оны эхний хагас жилд 2 удаагийн төрийн албаны сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулсан талаар:*



### **Дөрөв. Сургалт, судалгаа, сурталчилгаа хийх талаар:**

Төрийн байгууллага Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-т заасны дагуу төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2, 24, 29 дүгээр зүйл, 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалтад төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, мөн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн чадавхжуулах, ажлын байранд нь мэргэшүүлэх төлөвлөлтийг байгууллагын төсөвтэй уялдуулан хийж, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийн хүрээнд аймгийн 142 төрийн байгууллагын 73 нь буюу 51.4 хувь нь



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах давхардсан тоогоор 12 сэдвийн хүрээнд 43 удаагийн сургалтад 1500 гаруй төрийн албан хаагчийг хамруулсан.

### Сүүлийн 4 жилийн байдлаар сургалт зохион байгуулсан байдал:



Төрийн албаны тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч, иргэдэд сурталчлах зорилгоор тус салбар зөвлөлөөс видео, нэвтрүүлэг, постер зэргийг бэлтгэн Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл цахим



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

групп, аймгийн [www.bayankhongor.gov.mn](http://www.bayankhongor.gov.mn) албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилж байна.



### Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлаар зохион байгуулсан ажил, үр дүн, түүний хэрэгжилтийн талаар:

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 125,656,490 төгрөг, ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр 119,900.000 төгрөгийн санхүүжилтийг тус тус шийдвэрлэсэн байна.

Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс Улсын Их Хурлын “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам” батлах тухай 21 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох болзол шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгуулах саналыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлж байна.

Эхний хагас жилийн байдлаар болзол, шаардлагыг хангасан 25 төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, саналыг аймгийн Засаг даргад уламжилж, аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**Төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон байдал:**



**2022 оны эхний хагас жилийн байдлаар зэрэг дэв олгосон байдал:**



Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах журамд заасан болзол, шаардлага хангасан төрийн захиргааны байгууллагад тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан 2 албан хаагчийн материалыг хүлээн авч хэлэлцэн “Төрийн албаны Тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахаар уламжилсан.

**Төрийн албан хаагчийн тангараг:**

Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Төрийн албаны тухай хуулийн 22, 27, 28, 31 дүгээр зүйлд заасан шаардлага, болзлыг хангаж, төрийн албан хаагчийн зорилго, зорилт, чиг үүргээ мэргэжил ур чадварын зохих түвшинд



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

амжилттай гүйцэтгэж байгаа албан хаагчдаар “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг” өргүүлэх ёслолын ажиллагааг 2022 оны 05 дугаар сард зохион байгууллаа.



Төрийн жинхэнэ албан хаагчийн тангаргийг нийт 12 байгууллага, 3 сумын 36 төрийн албан хаагчаар нэр төртэйгөөр өргүүлж, тэмдэглэлийг хүргүүлсэн.

Төрийн албаны тухай хууль, холбогдон гарсан журам, дүрэм, салбар зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг аймгийн

[www.bayankhongor.gov.mn](http://www.bayankhongor.gov.mn) цахим

хуудас,

[www.facebook.com/Баянхонгор](https://www.facebook.com/Баянхонгор)

аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл хаяг, салбар зөвлөлийн мэдээллийн самбарт байршуулан мэдээлэн ажиллаж байна.



### Санал:

1.Төрийн албаны тухай хуульд “төрийн алба улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх” гэсэн зарчим МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ хуульд орсон өөрчлөлттэй зөрчилдөөд байна. Иймд энэ талаар нэгдсэн зөвлөмж чиглэл өгөх;

2.Төрийн албан хаагчдын цалин хөлсийг ялгавартайгаар нэмсэн. Үүнд нэгдсэн бодлого зохицуулалтаар арга хэмжээ авах;



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

3. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагийн албан тушаалын тодорхойлолтыг эргэж харах;

4. Төрийн албаны тухай хууль, төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэхэд Салбар зөвлөл эрх хэмжээнийхээ хүрээнд зөвлөмж, тогтоол, албан бичгийг гаргаж, сургалт, арга зүйгээр ханган ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн тодорхой зөвлөмж, чиглэл бидэнд хэрэгтэй байна.

ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

ХЯНАСАН  
ТАЙЛАН БИЧСЭН

Д.ЭНХЖАРГАЛ  
Б.НЯМДУЛАМ



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны 06 дугаар сарын 17

Номгон

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>Стратегийн зорилго: Төрийн албаны манлайлалыг бэхжүүлэн, ёс зүй, чадавхуйн зарчмыг төлөвшүүлж, үйл ажиллагааны чанар хүртээмж, ил тод байдлыг сайжруулна.</b>							
<b>Зорилт-1. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх замаар ёс зүй, сахилга хариуцлагатай төрийн алба, төрийн албан хаагчийг төлөвшүүлнэ.</b>							
1.1	Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахад мэргэшил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	2.0	Сургалтын тоо	129	150	Давхардсан тоогоор 43 удаагийн сургалтад 1500 гаруй төрийн албан хаагчийг хамруулсан.	100
1.2	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнд үндэслэн холбогдох шийдвэрийг гаргах, хэрэгжилтэд хяналт тавих	2.0	Байгууллагын тоо	142 байгууллагад ажилласан.	184 төрийн байгууллага	Энэ оны 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн. Хугацаа хүлээгдэж байна.	0
1.3	Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион	1.0	Зөвлөн туслах ажлын тоо	82	110	Төлөвлөгөөний дагуу 2022 оны эхний хагас жилд Эрдэнэцогт, Баянговь сумдын 6 байгууллагын 120 гаруй төрийн	100

1	2	3	4	5	6	7	8
	байгуулж, ёс зүйн зөвлөлүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх					албан хаагчдад, Орон нутгийн өмчийн газар, Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 40 гаруй, нийт 170 гаруй төрийн албан хаагчдад "Төрийн албаны үнэт зүйлс, ёс зүй" сэдвээр сургалт, зөвлөн туслах ажлыг хийсэн.	
1.4	"Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба" аян зохион байгуулж, үр дүнг тайлагнах	2.0	Зарласан аяны тоо	1	1	<p>"ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА ЗӨВТЭЙ ТӨРИЙН АЛБА" АЯНЫГ 2 ДАХЬ ЖИЛДЭЭ 3 САРЫН ХУГАЦААНД ӨРНҮҮЛЖ, ҮР ДҮНГ ДҮГНЭВ.</p> <p>Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор "Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба" аяныг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний хооронд зохион байгууллаа.</p> <p><b>Аяны хүрээнд:</b></p> <p>1.Төрийн байгууллагууд иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл авах үйл ажиллагаагаа хялбаршуулж давхардсан тоогоор 12 төрийн үйлчилгээгээ QR кодлуулжээ.</p> <p>2. "ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЭЛЬЕ-ШИНЭЧЛЭЛИЙГ ШИЛДГЭЭСЭЭ СУРАЛЦЪЯ" уриан доор нийт 28 төрийн байгууллага шилдэг ажилчдынхаа туршлагыг</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>түгээх сургалт, уулзалтуудыг зохион байгуулж, төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн байна.</p> <p>3. Аймгийн төвийн 24 байгууллага, 4 сум "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгууллаа.</p> <p>Нээлттэй хаалганы өдөрлөгөөр байгууллагууд 50 гаруй төрлийн үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилж, иргэдийн гомдол, санал, хүсэлтийг сонсох, хүлээн авах, газар дээр нь үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэж болохуйц санал хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэн ажилласан байна. Өдөрлөгийн үеэр нийтдээ 5000 гаруй төрийн албан хаагчдад шуурхай үйлчилгээ, мэдээллийг өгч ажиллав.</p> <p>4. Төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагын өнөөгийн байдлыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх бодлого чиглэл, ажил, арга хэмжээнд ашиглах зорилгоор Ёс зүй, харилцаа, хандлагын талаарх судалгааг аймгийн 85 байгууллагын 455 албан албан хаагчдаас авлаа.</p> <p>Судалгаагаар тус аймгийн нийт төрийн байгууллагын 90 хувь нь байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөлөө байгуулан ажилладаг ч үйл ажиллагаа нь хангалттай сайн</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>биш, жилд 1-2 удаа сургалт зохион байгуулсан.</p> <p>5. "Зөв харилцаа-ээрэг хандлага", "Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албаны үнэт зүйлс зэрэг сэдвээр нийтдээ 23 байгууллага, 1200 гаруй төрийн албан хаагчдад сургалт мэдээлэл өгч ажиллажээ. Энэ сарын 21-ний өдөр зохион байгуулсан Канадын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Салбар зөвлөл хамтран "Төрийн албан хаагчийн шударга, зарчимч байдал ба стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага" сэдэвт сургалтын үеэр "Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба" аяны тайлан, үр дүнг салбар зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, аяны хүрээнд тавьсан зорилтуудыг үр дүнтэйгээр хэрэгжүүлж ажилласан учир урамшуулах шийдвэр гарган, 9 байгууллагад талархал гардуулсан.</p> <p><b>Аяныг зохион байгуулснаар дараах үр дүнд хүрсэн.</b></p> <p><input type="checkbox"/>Аймгийн хэмжээнд төрийн албаны нэр хүнд дээшилж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдсэн.</p> <p><input type="checkbox"/>Аяны хүрээнд Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг</p>	

1	2	3	4	5	6	7	8
						сурталчлах, таниулах зэрэг ажлыг эрчимжүүлсэн нь Төрийн албаны шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болж байна. □Салбар зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбох өргөдөл, гомдлын тоо 33 хувиар буурав.	
<b>Зорилт-2. Чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, бүтээмжтэй төрийн алба, төрийн албан хаагчийг төлөвшүүлнэ.</b>							
2.1	Аймгийн хэмжээнд шаардлагатай байгаа мэргэжилтэй боловсон хүчний нөөцийн судалгааг хийх	1.0	Судалгааны тоо	Суурь судалгаа байхгүй.	Шаардлагатай хүний нөөцийн нэгдсэн судалгаатай болсон байна.	Төрийн мэргэшсэн албан хаагч 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах зорилгоор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд хэрэгцээтэй байгаа мэргэжилтэй боловсон хүчний судалгааг гаргах ажлын хэсгийг томилж, судалгааг хийсэн. Судалгаанд үндэслэн Төрийн мэргэшсэн албан хаагч 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийн боловсруулж, салбар зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлэн болсон.	30
2.2	"Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2025 онд дэд хөтөлбөрийг боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавих	1.0	Хэрэгжилтийн хувь	-	30	Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулдаг 7:4:10 суургалтын хүрээнд зохион байгуулсан 6 багц сэдвээр 24 удаагийн сургалтад онлайнаар хамрагдсан.	30
2.3	Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулж, сургалтанд хамруулах, терник тоног төхөөрөмжөөр хангах	2.0	Хамрагдсан сургалтын тоо	1	4	Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулдаг 7:4:10 суургалтын хүрээнд зохион байгуулсан 6 багц сэдвээр 24 удаагийн сургалтад онлайнаар хамрагдсан.	70



1	2	3	4	5	6	7	8
						Канад улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн шударга, зарчимч байдал ба стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага" сэдэвт сургалтад салбар зөвлөлийн дарга, 4 гишүүн хамрагдсан.	
<b>Зорилт-3. Төрийн албан хаагчийн тогтвортой ажиллах, нийгмийн баталгааг хангах нөхцөлийг бэхжүүлнэ.</b>							
3.1	Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангахад төрийн байгууллагын авч хэрэгжүүлж байгаа бодлого үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө дэмжлэг өгөх, хэрэгжилтийг эрчимжүүлэх	1.0	-Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах	Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгаа хангалтгүй.	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдсан байна.	Энэ оны 3, 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн. Хугацаа хүлээгдэж байна.	0
3.2	"Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдэгээр шагнаж урамшуулах журмын болзол, шаардлагыг хангасан албан хаагчдын тодорхойлолтыг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, саналыг уламжлах	-	Уламжилсан материалын тоо	Болзол, шаардлагыг хангасан 5 албан хаагчдын тодорхойлолтыг уламжилсан	Болзол, шаардлагыг хангасан албан хаагчдын тодорхойлолтыг уламжилсан байна.	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах журамд заасан болзол, шаардлага хангасан төрийн захиргааны байгууллагад тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан 2 албан хаагчийн материалыг хүлээн авч Салбар зөвлөлийн 2022	100

1	2	3	4	5	6	7	8
						оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар хуралдаанаар хэлэлцэн "Төрийн албаны Тэргүүний ажилтан" цол, тэмдэгээр шагнуулахаар уламжилсан.	
3.3	Төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох асуудлыг хэлэлцэн аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх	-	Зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон төрийн албан хаагчийн тоо	103	Холбогдох хууль, журамд заасан шалгуур хангасан төрийн албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон байна.	Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс Улсын Их Хурлын "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам" батлах тухай 21 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох болзол шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгуулах саналыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлж байна. Болзол, шаардлагыг хангасан 25 төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, саналыг аймгийн Засаг даргад уламжилж, аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.	100
3.4	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг	-	Хүний нөөцийн нэгдсэн	4780 төрийн албан хаагч	Мэдээлэл бүрэн оруулсан байна.	Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор	100

1	2	3	4	5	6	7	8
	цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, төрийн албаны стандартын хэрэгжилт, хяналтыг сайжруулж, байгууллагуудын хүний нөөцийн бодлого үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах		системд төрийн албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулсан байна.			батлагдсан "Улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх журам"-ын дагуу тус салбар зөвлөлд харьяалагдах 181 төрийн байгууллага дээрх системийг хөтлөн явуулдаг.	
Зорилт-4. Чадахуйн зарчимд суурилсан төрийн албаны хүний нөөц бүрдүүлэх зорилгоор бүх төрлийн сонгон шалгаруулалтыг ил тод, шударга явуулж, сул орон тооны нөхөн хангалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.							
4.1	Төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулж, сул орон тоог нөхөх	0.3	Шалгалт зохион байгуулсан тоо Зөрчил гараагүй байх Нөхөгдсөн сул орон тоо	0	Сул орон тоо гарсан тухай бүр шалгалт зохион байгуулах	Эхний хагас жилийн байдлаар Төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалын 4 удаагийн давхардсан тоогоор 38 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг нийтэд зарлаж, 3 удаагийн шалгалтыг зохион байгуулж, 14 сул орон тоог нөхсөн. Сүүлийн нийтэд зарласан шалгалтыг 2022 оны 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулна.	100
4.2	Төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулж, сул орон тоог нөхөх	0.3	Шалгалт зохион байгуулсан тоо Зөрчил гараагүй байх Нөхөгдсөн сул орон тоо	1 удаагийн шалгалтаар 86 сул орон тоог зарлаж, 23 нөхөгдсөн.	Сул орон тоо гарсан тухай бүр шалгалт зохион байгуулах	Эхний хагас жилийн байдлаар Төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх албан тушаалын 4 удаагийн давхардсан тоогоор 326 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг нийтэд зарлаж, 3 удаагийн шалгалтыг зохион	100

1	2	3	4	5	6	7	8
						байгуулж, 77 сул орон тоог нөхсөн. Сүүлийн нийтэд зарласан шалгалтыг 2022 оны 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулна.	
4.3	Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж сул орон тоог нөхөх	0.3	Шалгалт зохион байгуулсан тоо Зөрчил гараагүй байх Нөхөгдсөн сул орон тоо	1	Сул орон тоо гарсан тухай бүр шалгалт зохион байгуулах	Эхний хагас жилийн байдлаар Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 1 удаагийн 11 сул орон тоог нөхөх шалгалтыг нийтэд зарлан, зохион байгуулж, 8 сул орон тоог нөхсөн.	100
4.4	Төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалт зохион байгуулах	1.5	Шалгалт зохион байгуулсан тоо Зөрчил гараагүй байх Нөхөгдсөн сул орон тоо	2	2-оос дээш	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам", Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тов, чиглэлийн дагуу 4 дүгээр сард шалгалтыг зохион байгуулж, 62 иргэний ерөнхий нөөцийг бүрдүүллээ.	100
4.5	Төрийн албаны тухай хууль тогтоомжийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах	1.0	Постер, видео, нэвтрүүлэгийн тоо	40	30 постер 3 видео 2 нэвтрүүлэг	5 төрлийн постер хийж цахим системд байршуулсан.	30
4.6	Аймгийн албан ёсны цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээллийг	-	Нийтэлсэн мэдээллийн тоо	-	Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.	Төрийн албаны тухай хууль, холбогдон гарсан журам, дүрэм, салбар зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, хууль тогтоомжийн хүрээнд төрийн	100

1	2	3	4	5	6	7	8
	тогтмол байршуулж, ил тод байдлыг хангах					байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг аймгийн <a href="http://www.bayankhongor.gov.mn">www.bayankhongor.gov.mn</a> цахим хуудас, <a href="http://www.facebook.com/Баянхонгор">www.facebook.com/Баянхонгор</a> аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл хаяг, салбар зөвлөлийн мэдээллийн самбарт байршуулан мэдээлэн ажиллаж байна.	100
4.7	Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зар, мэдээ, мэдээллийг <a href="http://www.csc.gov.mn">www.csc.gov.mn</a> , Орон нутгийн мэдээллийн хэргслүүд, мэдээллийн самбарт сурталчлах.	-	Зар, мэдээ, мэдээллийн тоо	-	Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.		
<b>Дундаж дүн</b>							<b>86,6%</b>

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/ Д.ЭНХЖАРГАЛ /

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА



/Л.МАНДАЛ/

ТАЙЛАГНАСАН:  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

/ Б.НЯМДУЛАМ /

**Сахилгын шийтгэл хүлээсэн төрийн захиргааны албан хаагчдын судалгаа  
/Баянхонгор аймаг/**

2022 оны 06 дугаар сарын 17

Номгон

А/д	Сахилгын шийтгэл хүлээлгэсэн байгуулага, албан тушаалтан	Сахилгын шийтгэл хүлээлгэсэн албан бичиг /даргын тушаал/-ийн огноо	Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчийн албан тушаал	Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчийн нэр	Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчийн регистрийн дугаар	Сахилгын шийтгэл хүлээлгэсэн үндэслэл	Сахилгын шийтгэлийн төрөл	тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9
1	Түүх угсаатны зүйн музейн хамт олон	2022.02.01 Б/07	Нягтлан бодогч	Б.Намсрай	ВЮ65091914	Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.2 Байгууллагын дотоод журмын 8.7 Хамт олны хурлын шийдвэр	Нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах	
2		2022.02.01 Б/07	Харуул	Б.Мөнхэрдэнэ	ВК94082535	Хөдөлмөрийн тухай хуулийн 100.1 Байгууллагын дотоод журмын 7.2.1 Хамт олны хурлын шийдвэр	Нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах	
3		2022.02.01 Б/05	Тайлбарлагч	Т.Батсүрэн	ВЕ78102217	Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.2 Байгууллагын дотоод журмын 7.3.7 Аймгийн Засаг даргын 2020 оны А/01 захирамж, 01 дүгээр албандаалгавар Хамт олны хурлын шийдвэр	Үндсэн цалинг 3 сар хүртэлх хугацаагаар 20% бууруулах	
4	Эрдэнэмандал сургууль	2022.03.10 Б/14	Жижүүр	Б.Эрдэнэ- очир	ВК71122036	Хөдөлмөрийн тухай хуулийн 123.1, 123.2.3 дахь заалтыг тус тус үндэслэсэн.	Үндсэн цалинг 3 сар хүртэлх хугацаагаар 20% бууруулах	Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.1, 123.2.2 дахь заалтын дагуу үе шаттай арга хэижээ авсан.
5		2022.03.10 Б/15	Жижүүр	Н.Ганзориг	ВН69011735			
6		2022.03.14 Б/16	Жижүүр	Т.Дүгэрсүрэн	ВЭ68042211			
7		2022.03.14 Б/17	Жижүүр	Ж.Цэрэнжанцан	АЭ70061517			

1	2	3	4	5	6	7	8	9
8		2022.03.14 Б/18	Жижүүр	М.Лут-очир	ВЮ73081414			
9	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	2022 оны Б/31	Удирдлагын хэлтсийн дарга	А.Цэцэнбилэг	ВЮ76041126	Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дахь заалт 48.3 дахь хэсэг	Сануулах	Аймгийн засаг даргын 2021 оны дуудлага худалдаа зохион байгуулах А/711 дүгээр захирамжаар зарлагдсан дуудлага худалдааны газар нь Политехникийн коллеж авто дромын газартай давхцсан албан тушаалын тодорхойлолтонд заасан чиг үүргийг зөрчсөн
10		2022оны Б/30	Газрын зохион байгуулалт, төлөвлөлт газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	С.Должинсүрэн	ВЮ89120906	Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дахь хэсэг заалт 48.3 дахь хэсэг	Сануулах	
11	Мал эмнэлгийн газар	2022.05.10	Сахиул	М.Жасрай	ВЕ65040611	Ажлын байранд архидан согтуурсан	сарын үндсэн цалинг 3 сар хүртэлх хугацаагаар 20% бууруулах	
12		2022.05.10	Өвчний мэдээ тайлан цахим бүртгэл хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Б.Дэлгэрдалай	ВГ92031418	Мал амьтны гоц халдварт Шүлхий өвчний цаг үеийн мэдээг удаа дараа хоцроосон.	Сануулах	
13		2022.05.10	Ийлдэс судлал, шимэгч судлалын шинжээч эмч	Б.Анхзаяа	ВЖ94112819	Шинжилгээний явцад техникийн алдаа гаргаж, ажлын хариуцлага алдсан.	Сануулах	
14	Мэргэжлийн хяналтын газар	2022.01.11 Б/05	Боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч	Б.Одгэрэл	ВМ76030707	Ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын цагаас удаа дараа хоцорсон	Цалинг 1 сарын 20% бууруулсан	

1	2	3	4	5	6	7	8	9
15	Орон нутгийн өмчийн газар	2022.04.18 Б/07	Худалдан авалт төлөвлөгөө тайлан хариуцсан мэргэжилтэн	С.Рэнцэнбямба	ВГ70121235	Ажлын 2 өдрийг шалтгаангүйгээр тасалсан	3 сар хүртэлх хугацаагаар үндсэн цалингийн хэмжээг 20% бууулах	
16		2022.05.30 Б/11	Худалдан авалт хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн	Б.Цэрэнлхагва	ВГ87020415	Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 д заасныг зөрчсөн	3 сар хүртэлх хугацаагаар үндсэн цалингийн хэмжээг 20% бууулах	
17	Хөгжимт драмын театр	2022.02.21 Б/10		М.Мөнхтогтох	вю96061201	ХТХ-ийн 123.1, 123.2.1, 123.3	сануулах	Шалтгаангүйгээр 3 хоног ажил тасалсан.
18		2022.04.21 Б/16		Г.Батсуурь	ВЮ62091275	ХТХ-ИЙН 41.1.4, 123.2.3, 123.3	3 сараар цалинг 20% бууруулах	Жижүүртэй үедээ ажлын байр орхиж явсан.
19		2022.04.19 Б/25		Д.Энхбаяр	ВЮ70020571	ХТХ-ийн 123.1, 123.2.3, 123.3	2 сараар цалинг 20% бууруулах	Ажилдаа хайнга хандсан, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй
20	Эрдэнэмандал сургууль	2022.03.10 Б/14	Жижүүр	Б.Эрдэнэ-Очир	ВК71122036	Хөдөлмөрийн тухай хуулийн 123.1, 123.2.3 дахь заалтыг тус тус үндэслэсэн	Үндсэн цалинг 3 сар хүртэлх хугацаагаар 20% бууруулах	Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.1, 123.2.2 дахь заалтын дагуу үе шаттай арга хэижээ авсан.
21		2022.03.10 Б/15	Жижүүр	Н.Ганзориг	ВН69011735			
22		2022.03.14 Б/16	Жижүүр	Т.Дүгэрсүрэн	ВЭ68042211			
23		2022.03.14 Б/17	Жижүүр	Ж.Цэрэнжанцан	АЭ70061517			
24		2022.03.14 Б/18	Жижүүр	М.Лут-Очир	ВЮ73081414			
25	Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар	2022.02.15 А/07	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн	Л. Отгонтуул	ВИ86082606	Удаа дараа ёс зүйн зөрчил гаргасан.	Цалингийн хэмжээг 3 сар бууруулах	



5								
1	2	3	4	5	6	7	8	9
26	Галуут сумын Засаг даргын Тамгын газар	2022.05.20 Б/11	Мандал 5 дугаар багийн Засаг дарга	Ч.Түмэнжаргал	ВК89012514	архидан согтуурсан	Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1, ганцаарчлан сануулсан	
27	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	2022.04.08 Б/47	Даргын туслах, бичиг хэргийн ажилтан	Э.Цэрэнтогтох	ВМ85012412	Ажил тасалж, ажлын сахилга хариуцлага алдсан	Нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах	

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

Б.НЯМДУЛАМ

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээ

Сум, байгууллагын нэр: Баянхонгор аймаг

2022 оны эхний хагас жилийн байдлаар

2022 оны 06 дугаар сарын 17

Номгон

№	Байгууллагын нэр	Ёс зүйн зөрчлийн товч агуулга	Гомдол, мэдээллийг хүлээн авсан үндэслэл (тохирох нүдэнд "1" тоог тавих)					Ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчийн ангилал				Зөрчлийг анх буюу давтан үйлдсэн аль нь болох		Хэрхэн шийдвэрлэсэн тухай					
			Гомдлоор	Мэдээлээр	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн	Байгууллагын дотоод хяналтаар илэрсэн	төрийн захиргааны албан хаагч		Төрийн үйлчилгээний албан хаагч	Төрийн тусгай албан хаагч	Анх	Давтан	Ёс зүйн зөвлөл ёс зүйн зөрчлийг шалган тогтоосон эсэх			Ёс зүйн хэм хэмжээний хариуцлагын төрөл		
								Удирдах албан тушаалтан	Гүйцэтгэх албан тушаалтан					ёс зүйн зөрчил тогтоогдсон гэж үзсэн	ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзсэн	эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр шалгаж тогтоосон	уучлал гуйхыг үүрэг болгох	Сануулах	Ёс зүйн зөрчил хүлээлгэх үндэслэлгүй гэж үзсэн
4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20			
1	Мал эмнэлгийн газар	Ажлын байранд архидан согтуурсан					1			1		1		1			1		
2	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Ёс зүйн зөрчил					1		1	1		1				1	1		
3	Галуут сумын Засаг даргын Тамгын газар	Архидан согтуурсан		1								1				1			
				1			2			1		2		3		2		1	

ДАРГА **ХЯНАСАН** Д.ЭНХЖАРГАЛ  
 НАРИЙН БИЧГИЙН **НЭРТГЭСЭН**  
 ДАРГА **Б.НЯМДУЛАМ**